ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 26 өдөр Дугаар 3/07 Бат-Өлзий сум

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бат-Өлзий сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцээд 93,7 хувьтай, ”тодорхой үр дүнд хүрсэн“ гэж үнэлсүгэй.

2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжээгүй болон хэрэгжих шатандаа байгаа ажлуудыг 2024-2028 онд үргэлжлүүлэн зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Орхонтуул)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЧИНБАЯР

6218259775
ХТҮ0608 9047581

My Dok D-A-4 togtool (ITKH)2024

622401042

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
3/07 дугаар тогтоолын хавсралт

# БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /2024 ОН/

2024.12.18 Өвт

| Зорилт, арга хэмжээ | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Зарцуулсан Хөрөн-гийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он: Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он: Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 8 |
| **НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД** | | | | | | | | |
| **Зорилт 1: Сумын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, иргэдийн амьжиргаатай уялдуулан мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ** | 1 | Малын гаралтай түүхий эдийг түшиглэж, ноос ноолуур, арьс, шир боловсруулах, элдэх, хүнсний ногоо боловсруулах цех байгуулах. | 2020-2024 | ХААТ | | Арьс шир элдэх, хүнсний ногоо боловсруулах цехтэй болсон байна. | 2023 оны 6-р сард 2-р багийн Засаг дарга Share Mongolia ХХК-тай хамтран багийнхаа 25 иргэнд цахилгаан багажаар 5 хоногийн хонь хяргах сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар 2350 толгой хонийг хярган өнгөөр болон үргэлж хэвийн, бутархай 2,6 тн ноосыг ангилж сумын “Дэлгэр баян ундрах” хоршоонд тушаасан.<br>Малчдын хамтын хүч хоршоо 2.5 сая төгрөгөөр сарлагийн хөөвөр самнах хашаа хийж 5 өрхийн 78 сарлагийг самнаж туршсан. Тус хоршоо 41 малчнаас 700 кг сарлагийн хөөврийг 20,0 төгрөгөөр, 167 малчнаас 3,8 тн ноолуурыг авч Үлэмж кашмер ХХК нийлүүлсэн. Борлуулалтын ашгийн зөрүүнээс 1 кг ноолуурт 1000-1500 төгрөгийн урамшуулал олгосон. Тус хоршоо өөрийн хөрөнгөөр нэхий элдэх иж бүрэн төхөөрөмж худалдан авч суурилуулан 4-р багийн иргэн Д.Дэлгэржаргалыг Улаанбаатар хотод 14 хоногийн сургалтад хамруулсан. Улаанбаатар хотоос нэхийний | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | технологичийг 10 хоногийн хугацаатай урьж авчран дадлага сургалтыг хийлгэн цех өдөрт 40-50 ширхэг нэхий элдэх хүчин чадалтай цехтэй болсон. 2021-2024 онд 110 өрхөд Орчны бүсийн 935,300,000 төгрөгийн зээл олгосон. | |
| | 2 | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж хэвшүүлэх | 2020-2024 | ХААТ | | ЖДҮ-ийг дэмжиж дунджаар 60 иргэн, ААН-ийг зээлээр дэмжсэн байна. | **Хоршоо хөгжүүлэх сангаас:** нийт 2 хоршоо, 44 иргэнд 414 сая төгрөгийн зээлийг олгосон. Үүнд: 2020 онд 22 иргэнд 118 сая, 2021 онд 13 иргэнд 49 сая, 2022 онд 1 хоршоо, 2 иргэнд 138 сая, 2023 онд 1 хоршоо 7 иргэнд 109 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон.<br>**Жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас**: Нийт 2 аж ахуй нэгж 324 сая төгрөгийн зээл олгосон. Үүнд: 2020 онд “Арвинлхам Очир” ХХК нь модон сав хийх чиглэлээр 45 сая төгрөг, 2023 онд “Их Сумт хайрхан” ХХК мод үржүүлгийн чиглэлээр 279 сая төгрөг тус тус олгосон.<br>**Монгол Улсын Засгийн газрын хүүгийн хөнгөлөлттэй зээлээс:** Банкаар дамжуулан нийт 222 иргэнд 3,7 тэрбум төгрөгийн зээл олгосон: Үүнд: 2021 онд 103 малчинд малын тоо толгойг өсгөх, малын үүлдэр угсааг сайжруулахад 643.2 сая төгрөг, 117 бизнес эрхлэгч иргэнд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх чиглэлээр 3.1 тэрбум төгрөгийн зээл олгосон. 2023 онд газар тариалангийн үйлдвэр эрхлэгч 2 иргэнд 46 сая төгрөгийн зээл олгосон.<br>2024 онд “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнөж 15 хоршоо шинээр байгуулагдан, мал аж ахуйн чиглэлээр төрийн банкнаас 15 хоршооны 74 малчин 36-60 сарын хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй 2,450.000.000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | 90 |
| | 3 | Сумын онцлог, өв уламжлалыг харуулсан | 2020-2024 | ЗДТГ ХААТ, | | 15 иргэнийг шинээр ажлын | Брэнд бүтээгдэхүүнтэй болох, үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор хоршоо | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брэндэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих ажлын байр бэлтгэх. | | | | байртай болгоно | хөгжүүлэх сангаас 2020 онд оёдлын чиглэлээр 2 иргэнд 8,0 сая төгрөг, ширмэл ширдэг ширэх чиглэлээр 1 иргэнд 4,0 сая төгрөг олгон 1 ажлын байр шинээр нэмэгдэж, 2 ажлын байр хадгалсан.<br>2021 онд "Жаргалхүү ХХК"-ийн Хатан зөгий үржүүлэх төсөлд 5 сая төгрөг, иргэн Ч.Цэрэндолгорын “Монгол дээл, монгол хувцас”-ны төсөлд 3 сая төгрөг, иргэн С.Даваанямын “Үндэсний урлан” монгол гутлын төсөлд 5 сая төгрөг олгон 4 ажлын байр хадгалсан.<br>2022 онд "Жаргалхүү ХХК"-ийн Зөгийн бүл нэмэх төсөлд 15,0 сая төгрөг олгон 2 ажлын байр хадгалсан.<br>2023 онд С.Давааням “Үндэсний урлан” монгол гутлын төсөлд 5,0 сая төгрөг, иргэн Ш.Чанцалням оёдлын чиглэлээр 5,0 сая төгрөг олгон 3 ажлын байр шинээр нэмэгдэж, 2 ажлын байр хадгалсан.<br>Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас иргэн Ч.Ганбаатарт арьс ширээр бүтээгдэхүүн хийх төсөлд 5,0 төгрөгийн зээл олгож 1 ажлын байр нэмэгдсэн.<br>2023 онд Иргэн А.Цэвэлмаа шар сүүн чихэр, М.Авиржаргал цайны ээзгий, Ж.Дагиймаа талх нарийн боов үйлдвэрлэж сав баглаа боодлыг оновчтой шинэлэг хэлбэрээр шийдэж 3 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн.<br>Шинээр 8 ажлын байр нэмэгдэж, 10 ажлын байрыг хадгалан ажиллаж байна.<br>2024 онд Хүрхрээн чимэг” хоршоо байгуулагдан сав баглаа боодлыг шинэлэг байдлаар шийдэн цайны ээзгий, борцтой хийцтэй цайг тус бүр 1000 ширхгийг хийж борлуулаад байна. Бүтээгдэхүүн хийх цагаан идээг 15 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | малчин өрхөөс авахаас гадна байнгын 1 ажлын байр бий болгосон. Шинээр 9 ажлын байр нэмэгдэж, 10 ажлын байрыг хадгалан ажиллаж байна. Бэлэг дурсгал зардаг 4 дэлгүүр, үндэсний дээл хувцас хийдэг ажлын байртай 3 иргэн үйл ажиллагаа явуулж байна. | |
| | 4 | Байгалийн нөөцийг зохистой ашиглах, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр 300 га хүртэл талбайг эзэмшүүлж эргэлтэд оруулна. | 2020-2024 | ХААТ | | 300 га-д малын тэжээл, жимс жимсгэнэ тариулсан байна | 2020-2023 онд малчид өвөлжөө, хаваржааны хөлд 8,6 га газарт ногоон тэжээл тарьсан. Билүүт, Онгоцот, Баруун сөдтийд нийт 53 га атаршсан газарт малын тэжээл тарьж эргэлтэд оруулсан. Чацаргана 1.4 га газраар нэмэгдүүлэн 1150 суулгац шинээр тарьсан. | 100 |
| | 5 | Сумын аялал жуулчлалын маршрутын дагуух зам, гүүр, дэд бүтцийн нөхцөлийг сайжруулах. | 2020-2024 | ЗДТГ | | Аялал жуулчлалын зам сайжирна | Хужирт-Бат-Өлзийг холбосон 49 км хатуу хучилттай зам, Наймаа булангийн арын зам /200м урттай 3 м өргөнтэй/, Бугатын хэжүү, Өвтийн улаан хадны зам /600 м урттай 5 м өргөнтэй/, Улаан амны хэжүүгийн зам /500 м урттай, 4 м өргөнтэй/, Бөхөн шарын даваа Тарвагатын ам хүртэл /4 км-ийн урттай, 4 м өргөнтэй, Хужирт нарийн Онгоцотын ам хүртэлх 10 жалга гарам, Өвтийн даваа /3 км/ зэрэг зам гармуудыг зассан. Ууратын даваа, Хүрдтийн хошуу /100 м урттай 2-3 м өргөнтэй/, Шавартын хэжлэг / 200 м урттай, 3 м өргөнтэй/, Амгалангийн богоч /250 м урттай/, Дунд-Ар жалгын уруулаг /30 м урттай/ зэрэг замуудыг засаж сайжруулсан.<br>Улааны голын гүүр, Хамрын амны гүүрийг иргэд, Мотор сервис ХХК-тай хамтран засварлан барьсан. | 90 |
| | 6 | Гурван модны хөвөөний замыг засах. | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа | | Аялал жуулчлалын зам сайжирна | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3,5 сая төгрөгөөр Гурван модны замыг засварласан. | 100 |
| **1.2. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 7 | Сумын төв доторх хатуу хучилттай замын дутууг гүйцээх | 2020-2024 | ЗДТГ | Улсын төсөв | 2 км | Сумын төвийн 1,2 км асфальтан авто замыг "Өв-Азза" ТӨХК гүйцэтгэн, ашиглалтад оруулсан. Дээд өргөн чөлөөний 900 м асфальтан авто замын ажлыг "Андрареүд" ХХК гүйцэтгэж байна. ажлын явц 50 хувьтай. | 70 |
| | 8 | Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн авто замыг шинээр барих зураг төсвийг хийлгэж барьж эхлэх. | 2020-2024 | ЗДТГ | Улсын төсөв 51,6 тэрбум | 49 км | Хужирт-Бат-Өлзий сумын асфальтан зам тавих тендер зарлагдаж, "Мотор сервис", "Өндөр сант хайрхан" ХХК-ууд гүйцэтгэхээр шалгарч 2024 онд замын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| | 9 | Наймаа булан, Өвт, Бэл хорооллын үерийн далан барих. | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа | ОНХСан | Үерийн далан баригдсан байна. | Наймаа булан, Өвт, Бэл хорооллын үерийн далан барих ажлын зураг төсвийг 2022 онд 20,0 сая төгрөгөөр хийлгүүлсэн. Үерийн далан барих ажлыг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийхээр 2023 оны төсөвт 162,2 сая төгрөг батлуулсан. Тус ажлын тендерийг 2 удаа зарлаж "Тулгат зам" ХХК шалгаран 1,2 366 метр урт даланг ажлыг гүйцэтгэсэн. | 90 |
| | 10 | Цаг уур, Наймаа булангийн 6 дугаар гудамжнаас хойш, Өвтийн 17 дугаар гудамжнаас хойш, Бэлийн 11 дүгээр гудамжнаас хойш өргөн чөлөөнд гэрэлтүүлэг тавих | 2020-2024 | ЗДТГ | | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Наймаа буланд 4 ширхэг, дунд өргөн чөлөөнд 9 ширхэг, доод өргөн чөлөөнд 8 ширхэг, цехийн урд зам дагуух гэрэлтүүлгийг гүйцээн, 3, 1 дүгээр Цэцэрлэгийн ард 2, Сургуулийн арын зам дагуу 7, Ерөнхий боловсролын сургуулийн баруун талын гэрэлтүүлэг 4, нийт 37 гэрэлтүүлэг суурилуулсан. Эдгээр гэрэлтүүлэг нь нэг тусгалтай 16 , 2 тусгалтай 21 гэрэлтүүлэг байна. | 100 |
| | 11 | Бүрэгтий багийн төвийг өндөр хүчдэлд холбох, худаг гаргаж суурьшлын бүс болгох. | 2020-2024 | ЗДТГ | ОНХСан 150,0 сая | | Тог татах шугамын ажлын тендерийг 2 удаа зарласан боловч нэг ч аж ахуйн нэгж тендерт ороогүй. ЭБЦТС, ОХБЦТХГ-аас тог татах цэгийн зөвшөөрөл авсан. | 70 |
| | 12 | Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг хариуцах чиг үүрэг бүхий | 2020-2024 | ЗДТГ | ОНТөсөв 19,0 | | Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг ТӨҮК-д гэрээгээр гүйцэтгүүлж байгаа, одоогоор 4 орон тоотойгоор ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгж байгуулж, бүтэц орон тоо бий болгох | | | | | | |
| | 13 | Улаан голыг төмөр бетон хийцтэй хөлтэй, модон тавцантай гүүр барих | 2020-2024 | ЗДТГ | 250,0 | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Улааны голд төмөр бетон гүүрийг “Мотор сервис” ХХК 2021 онд 250,0 сая төгрөгөөр барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100 |
| | 14 | Улиастай болон Улаан-Амны багийн төвийн барилга барих. | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа | ОНХС 60,0 | | 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Улаан амны багийн төвийг “Үлэмж шинэ хээ” ХХК 53,9 сая төгрөгөөр барьж гүйцэтгэсэн. 6 дугаар багийн төв барих ажлыг 2025 онд хийхээр төлөвлөсөн. | 70 |
| | 15 | Сумын төвд цамхагт гэрэлтүүлэг 2-ыг барих. | 2020-2024 | ЗДТГ, Бизнесийн холбоо | | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Цаг Уур, Рамын дэнжид 1, ЗДТГ-ын төв талбайд 1, Багийн төвийн баруун талд 1, Үржүүлэхэд 2, Жогом хорооллын замд-1, шинэ сургууль цэцэрлэгийн дунд 6 нийт 6 ширхэг 6 талтай Цамхагт гэрэлтүүлэгтэй болсон. 2024 онд 12 ширхэг гэрэлтүүлгийн толгой сольсон, 55 ширхэг 100 жилийн логотой гэрэл, 1 цамхагт гэрэлтүүлэг, 1 талтай 6 шинэ гэрлийг нэмж тавьсан. | 100 |
| | 16 | Улаан-Ам багийн Улааны хэжүү, Амгалангийн хошууны замыг засварлах | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа иргэд | | 2 зам засварлагдсан байна. | 2021 онд Улаан-Ам багийн Хэжүүгийн замыг “Мотор сервис” ХХК өргөсгөж, 2024 онд “Их сумт хайрхан” ХХК зам засварын ажлыг 6,5 сая төгрөгөөр засварлаж дууссан.<br>Улиастай багийн Уурагтын даваа, Хүрдтийн хошуу, Шавартын хэжлэг, Амгалангийн богч, Дунд ар жалгын амны замыг иргэн Б.Түвшинжаргал, иргэдийн оролцоотойг засварласан. | 100 |
| | 17 | Зөрүүлэг багт нийтийн халуун ус барих. | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа | ОНХС 57,6 сая | | 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Зөрүүлэг багт нийтийн халуун усыг “Бага хайлантай” ХХК 57,7 сая төгрөгөөр барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 18 | Ахмадын хөгжлийн төвийг шинээр барьж, ашиглалтад оруулна. | 2020-2024 | ЗДТГ, Ахмадын хороо | 40,0 | | Цагдаагийн хуучин кабон байрыг Ахмадын байр болгон улсын төсвийн 40,0 сая төгрөгийн хөрөнгөөр бүрэн засварлаж ашиглалтад оруулсан. | 90 |
| | 19 | Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болгох. | 2020-2024 | ЗДТГ, Бизнесийн холбоо | | | 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болох ажилд 130,0 сая төгрөгийн төсөв батлуулсан. Тус ажлын тендерийг 4 удаа зарласан боловч нэг ч ААН оролцоогүй. Сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2 дугаар хуралдаанаар 2025 онд дахин тендер зарлах шийдвэр гарсан. | 50 |
| | 20 | Хүүхдийн “Хөдөлмөр амралтын зуслан” шинээр барьж ашиглалтад оруулна. | 2020-2024 | ЗДТГ, ХААТ | | | Улаан-Ам багийн төвийн бага сургуулийг түшиглэн хүүхдийн “Орхон Хөдөлмөр зуслан” ажиллуулахаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас санхүүжилт шийдүүлэхээр хүсэлт уламжилсан. 2024 оны 8 сард туршилтаар 1 ээлжээр ажиллуулсан. | 70 |
| | 21 | Улс, аймгийн хамгаалалтад байдаг болон Дэлхийн өвд бүртгэлтэй түүх соёлын дурсгалтуудыг дэс дараалалтайгаар хашаажуулж, хамгаалалтыг сайжруулна. | 2020-2024 | ЗДТГ, Соёлын төв | | | 2021 онд Улсын хамгаалалтад байдаг Төвхөн хийдийг хамгаалахаар Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газраас 1 хүний орон тоог баталж, орон нутгаас 1 иргэнийг ажиллуулсан. Бөхөн шарын Адгийн буган чулуу, Өндөр хясааны буган чулуу, Урд-Агуйтын булш хэрэгсүүл, Хөшөө хонхрын хөшөөний хашааг сэргээн засварласан.<br>2022 онд Аймгийн хамгаалалтад байдаг 1 дүгээр багийн нутаг Өндөр хясааны буган чулууны хөшөөг бетонон суурьтай, 1,5 $м^2$ төмөр хайсан хашааг барьсан. Мөн Дэлхийн өвд бүртгэлтэй Зөрүүлэг 4 дүгээр багийн Ширээт уулын буган чулууны хөшөө булш хэрэгсүүрийн цогцолбор дурсгал /зуухны ам/-ын “Танилцуулах самбар”-ыг нийт 1,298,0 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мянган төгрөгийн санхүүжилтээр хийж, хамгаалан иргэдэд сурталчилсан. | |
| | 22 | Зүүн сөдтийн Дунд халзангийн даваа, орон нутгийн чанартай шаардлагатай замуудыг засварлах. | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа | | | 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бүрэгтий багийн Бугатын амны хэжүүгийн замыг “Хансэнтий” ХХК 18,8 сая төгрөгөөр засварласан. Гүйцэтгэл 100 хувьтай. Өвтийн Улаан хадны замыг Бат-Өлзий Тохижилт үйлчилгээний компани 2,9 сая төгрөгөөр, Бөхийн шар, Урд Агуйтын замыг иргэдийн оролцоотой засварласан.<br>2024 онд Могой, Мойлт замыг 9,900,000 төгрөг, Өвтийн Мөстийн зам засварын ажлыг 4,999,000 төгрөгөөр “Их сумт хайрхан” ХХК гүйцэтгэсэн. | 70 |
| | 23 | Хогийн цэг рүү цахилгааны шугам татах | 2020-2024 | ЗДТГ, ТӨҮГ | 10,0 | Цахилгааны эх үүсвэртэй болох | 2020 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хогийн цэг рүү цахилгаан шугам татсан. | 100 |
| **1.3 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ** | | | | | | | | |
| Зорилт: Байгаль цаг уурын нөхцөлд зохицсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулах, усан хангамжийг нэмэгдүүлэх төмс, хүнсний ногоогоор дотоодоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 24 | Сумын төвийн тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотойгоор аж ахуйн нэгж байгуулан газар тариалан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллуулна. | 2020-2024 | ХААТ | | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 82,0 сая төгрөгөөр 80 морины хүчин чадалтай трактор дагалдах эд анги анжис, борной, төмс үрлэгч зэргийг авч ашиглаж байна | 100 |
| | 25 | Сумын өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд “Атаршсан талбай”-г эргэлтэд | 2020-2024 | ЗДТГ, ХААТ | | Атаршсан газарт ногоон тэжээл тариална. | Билүүт, Онгоцот, Баруун сөдтийн атаршсан 200 га талбайг эргэлтэд оруулахаар хэмжилт хийн эзэнжүүлэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулж 200 га-аас доошгүй газарт ногоон тэжээл тариална. | | | | | олгосон. Үүнээс 53 га талбайд малын тэжээл тарьсан. | |
| | 26 | Стандартын шаардлага хангасан “Мал нядалгааны цэг” байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин газрын асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана. | 2020-2024 | ЗДТГ, ААН, иргэн | | | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 19/05 дугаар тогтоолоор 180 сая төгрөгийн өртөгтэй мал нядалгааны цэг байгуулах шийдвэр гарч тендер зарлан “Шоо констракшн” ХХК шалгаран Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай гэрээ байгуулсан. Тус компани нь мал нядалгааны цэгийг барьж дууссан. | 100 |
| | 27 | Хүнсний ногооны зоорь байгуулах иргэн, аж ахуйн нэгжийн саналыг дэмжин газрын асуудлыг шийдэж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад анхаарч төсөл, хөтөлбөрөөр дэмжин хамтран ажиллана. | 2020-2024 | ЗДТГ, ХААТ | | | Төмс, хүнсний ногооны зоорийг орон нутгийн хөрөнгөөр 50 хувь, “Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл”-өөс 50 хувийн санхүүжилтээр нийт 80 сая төгрөгөөр 55 тн багтаамжтай зоорийг барьсан. | 90 |
| | 28 | Сумын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Улиастай” багийн Улиастайн дэнжийн нам оруулга, Горхин дэнж, Улаан ам багийн Мухдаг, Бүрэгтий багийн төв, Дэндгэр, Билүүтийн хөндлөн, Баруун сөдтий, Зөрүүлэг багийн Урд Агуйт, Нарийн, Хойд Агуйт, 5 дугаарт баг, Могойтын ам зэрэг газарт худгуудыг шинээр гаргах. | 2020-2024 | ЗДТГ, ХААТ | | Баригдсан худгуудын тоогоор | 2020-2023 онд нийт 5 худаг шинээр гарсан. Үүнд: 1 дүгээр баг Мухдаг, 2 дугаар баг Билүүтийн Гэзэг, Баруун сөдтийн Шар мухарт, Зүүн сөдтийн Нураг, 4 дүгээр баг Урд-Агуйт тус тус шинээр худаг гаргасан.<br>2024 онд Улиастайн дэнж, Галт, Билүүтийн хөндлөн, Гуяын нуруу зэрэг газарт худаг, цооног гаргах ажлыг “Хутагт-Уулын Өгөөж” ХХК гүйцэтгэж байна. Төсөвт өртөг 69.0 сая төгрөг. | 90 |
| | 29 | Малын гоц болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж Улиастай багийн Боймт, Шивэртий, Бөөрөг, Улаан ам багийн Бургас, | 2020-2024 | ЗДТГ, МЭТ | | Тарилгын хашааны тоогоор | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт тарилга гүйцэтгэх, эрүүл бүс, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж Сум дундын ойн анги”-тай хамтран тарилгын хашааны модны зөвшөөрлийг авч 1, 6 дугаар багийн Боймт, Шивэртий, Бөөрөг, Мухдагт нийт малын тарилгын 5 хашаа баригдсан. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мухдагт мал тарилгын хашаа барина. | | | | | 2 дугаар багийн Зүүн, Баруун сөдтийд 3 хашаа, 3, 4 дүгээр багуудад нийт 5 малын тарилгын хашааг барьсан. 2024 онд Хүйтэн булаг 5 дугаар багт ОНХС-ийн санхүүжилтээр мал тарилгын хашаа барих ажлыг иргэн Д.Дорждэрэмтэй гэрээ байгуулж, гүйцэтгүүлж байна. Төсөвт өртөг 2,800,000 төгрөг. | |
| | 30 | Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг тогтмолжуулж Бүрэгтий багийн Баруун сөдтийд мал угаалгын ванн барина. | 2020-2024 | | | Мал угаалгын ванны тоогоор | Бүрэгтий багийн Зүүн Сөдтийд баригдсан мал угаалгын ванныг ашиглалтад оруулж, Монгол улсын хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 01 дүгээр албан даалгаврын 3.3 дахь заалтаар батлагдсан шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх Угаалга 75000, Боловсруулалт 55000, Туулгалт-105100 нийт 235100 мянган толгой мал хамруулж 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. | 100 |
| | 31 | Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр малын эмч, нэгжүүдийн малын эмч нарыг хангах үйлчилгээг цахимжуулна. | 2020-2024 | ЗДТГ, МЭТ | | Мал эмнэлгийн үйл ажиллагааг цахимжуул на. | Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлэн мал эмнэлгийн гэрчилгээг цахимаар бичилт хийж, зурагжуулан баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд таблет болон хэвлэгч мини принтер ашиглан цаасан хэлбэрээр хэвлэж мөн цахимаар батлагдсан гэрчилгээг хэрэглэгчид тухай бүр илгээж хамтран ажиллаж байна. | 100 |
| **1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | | |
| **Зорилт 1: Гол ус, булаг шандын эхийг хамгаалах, аялал жуулчлалыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.** | 32 | Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагыг дэмжиж, сумын төвийн засмал зам дагуу ногоон байгууламжтай болгох, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ. | 2020-2024 | ЗДТГ, Ойн анги | 26,1 | 2500 | Бат-Өлзий сум нь “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны хаврын мод тарих арга хэмжээнд нийт 5 байгууллага, 7 аж ахуйн нэгж, 11 нөхөрлөл, 242 иргэн оролцож 8 төрлийн 43500 ширхэг мод, бут сөөг тарьсан. Ойжуулалтад 44000 тарьц суулгасан. Ургалт 85 хувьтай. Иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр 2 удаагийн | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт, багийн иргэдийн нийтийн хурлуудаар мэдээлэл хийж, нийт мод тарих аргачлалаар 800 гаруй ширхэг гарын авлага тараасан. Ойжуулалтын ажилд нийт 540 гаруй хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл улсын болон өөрийн хөрөнгөөр нийт 394.0 сая төгрөг зарцуулсан. “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэл 1 сая мод тарилт хийхээс нийт 284012 ширхэг мод тарьсан.<br>Сум дундын Ойн ангид 5 га, 1 аж ахуйн нэгжид 3 га, 3 иргэнд 1 га- мод үржүүлгийн газрын асуудлыг шийдвэрлэн тарьц суулгац бэлтгэх ажил жигдэрсэн.<br>Сумын төвийн зам дагуух нийт 6 төрлийн 54355 ширхэг мод, бут сөөг тарьсан. Ургалт 85 хувьтай. Сумын хэмжээнд цэцэрлэгт хүрээлэнгийн талбай 4, зам дагуух ногоон зурвас 2, бичил цэцэрлэгт хүрээлэн 1 байгуулагдсан. | |
| | 33 | Усны нөөц нэмэгдүүлэх, булаг, шандын эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх төслийг дэмжинэ | 2020-2024 | ЗДТГ, Байгаль орчин | 15,5 | 2 | Усны нөөц нэмэгдүүлэх, булаг шандын эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг 8 булгийн эх хашиж хамгаалсан. Асгана булгийн эх, Мойлтод булгийн эх, Мухар хустын булгийн эх, Цагаан азарга булгийн эх, Урд-Агуйт, Цагаан гол, Намгийн булгийн эх, Улааны булгийн эх хаших ажлыг орон нутгийн төсвөөс 39,3 сая төгрөг зарцуулсан. Усны нөөц нэмэгдүүлэх, булаг шандын эх хамгаалах, нөхөн сэргээх ажлыг 12 булгийн эх хашиж хамгаалсан. Усан сан бүхий газруудад анхааруулах самбар 8 ширхгийг байршуулсан. | 100 |
| | 34 | Сумын хогны менежментийг сайжруулж, хог хаягдал дахин боловсруулах цех | 2020-2024 | ЗДТГ, ТӨҮК | 30,0 | 2 | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг өөрчлөн тогтоох шийдвэрт өөрчлөлт оруулахаар бичиг баримтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах, хог шатаах зуухтай болох | | | | | боловсруулж, ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн. Сумын хэмжээний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах худалдан авахаар тендер зарлан 3 байгууллагаас. “Өнгө нэм” ТББ шалгарч 20 сая төгрөгөөр гэрээ байгуулан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна. Тайланг танилцуулах ажлыг 12 дугаар сарын 19 нд танилцуулна. “Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” 2024 оны А/76 дугаар захирамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 25-27-ны хооронд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Нийт 4 удаагийн хог тархсан талбайг хумьж, отволдсон. 340000 м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэн 3654 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгасан. | |
| | 35 | Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хамгаалалтын менежментийг сайжруулна. | 2020-2024 | ЗДТГ | 15,0 | 2 | Хамгаалалтын менежментийн хүрээнд 03 дугаар сарын 03 ны өдөр Дэлхийн зэрлэг ан амьтан, ургамал хамгааллын өдрийг тохиолдуулан Өвтийн давааны Оно, Мухар хустын Бургас, Нууцат, Бөхөн шарын Зүүн,Баруун байц, Урд Агуйтын Асгат, нарийн нүүр гэх газар зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авч 250 боодол ногоон өвс, 250 кг хужир нутгийн иргэд, байгаль хамгаалагч нартай хамтарч тавьсан. 2025 оны биотехникийн арга хэмжээний нарийн ногоон өвсийг 350 боодол авч нөөцөлсөн. Нийт 15 сая төгрөгөөр санхүүжилт хийсэн.<br>2 аж ахуйн нэгж, 3 нөхөрлөл нийт шувууны үүр 25 ширхэг хийж тавьсан. | 70 |
| | 36 | Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулна | 2020-2024 | ЗДТГ ОХБЦГ | 45,0 | 1 | Төвхөн хийдийн угтах орчны камер суурилуулалтын ажил хийгдсэн. Мөн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хосгүй үнэт зүйлс хадгалах сейф 2 ширхэг тавигдсан байна. | |
| | 37 | Үүртийн тохой-Төвхөн хийд, Улаанцутгалан-Бат-Өлзий гэсэн аялал жуулчлалын маршрутаар хөгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 210,0 | 2 | Улаан цутгалангийн хүрхрээ, Төвхөн хийдийн орчинд 60 гаруй эко гэр, 12 аялал жуулчлалын бааз үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн БОАЖГазар, ОХБЦГХЗахиргаа, сумын ЗДТГазар хамтран аялал жуулчлалын бүс нутаг дэвсгэрийн талбайн хог хаягдлыг цэвэрлүүлж, аялал жуулчлал эрхлэгч 26 иргэнийг аймгийн политехникийн коллежид мэргэжлийн сургалтыг зохион байгуулан 22 иргэн амжилттай төгсөж, мэргэжлийн үнэмлэхтэй болсон. Орон нутаг, олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээ шаардлага, үйлчилгээний салбарын чанар стандартыг дээшлүүлэх боломж, нийгмийн болон ногоон бизнес, нүхэн жорлон, хог хаягдал зэрэг арга хэмжээний талаарх танилцуулга мэдээллийг хүргэлж, Улаан цутгалангийн эко гэрүүд нийтийн нүхэн нойлоо буулган 20 тн төмөр сав суулган нойлоо шинэчилсэн. Замын тэмдэг тэмдэглэгээ 16, хориглох үйл ажиллагааны тэмдэг 10 тодорхой цэгүүдэд тавигдсан. Аялал жуулчлал эрхлэгчдийн зөвлөгөөнийг сумандаа зохион байгуулж, нийт 130 гаруй иргэд оролцсон. Оролцогчдод орчны бохирдол, хог хаягдлын менежментийн талаар “Өнгө нэм” НҮТББ-тай хамтарч сургалт зохион байгуулсан. | 90 |
| | 38 | Найман нуур, Улаан голын Хүрхрээгийн мөсөнд авиралт, Өндөр хясааны сарлагийн фестиваль гэсэн тусгай сонирхлын аяллын маршрутыг хөгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 2 | Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын маршрутыг бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл болон брэнд бүтээгдэхүүнтэй болгох чиглэлээр аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр морин | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аялал, хөдөөгийн айлын ахуй амьдралтай танилцах аялал, 3 өдөр, 2 шөнийн аялал гэсэн төрлүүд бий болж байна. Найман нуур, Улаан голын Хүрхрээгийн мөсөнд авиралт 11 дэх жилдээ, Өндөр хясааны сарлагийн фестиваль нь 14 дэх жилдээ зохион байгуулагдаж аялал жуулчлалын брэнд болсон. | |
| **1.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | |
| Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ | 39 | Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ, НБМ | | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Гэр бүл төлөвлөлт, тогтвортой гэр бүл, гэр бүлийн эерэг харилцаа, архидалтын хор уршиг, хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх, хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулах зорилгоор “Гэр бүлийн үнэ цэн” уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан видео бэлтгэн олон нийтийн сүлжээгээр цацаж 9875 хүнд хүрсэн. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 7 удаагийн сургалт, 4 нөлөөллийн ажлыг зохион байгуулж 988 иргэн хамрагдсан. Мөн гарын авлага бэлтгэн 418 иргэнд тараасан. Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцооны чиглэлээр гарын авлага бэлтгэн 218 эцэг, эх, иргэдэд тараасан. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тогтвортой гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, угийн бичиг хөтлөхийн ач тус сургалтыг 2 удаа зохион байгуулан 129 иргэн хамрагдсан. 2024 оны 11 дүгээр сарын 8 нд I, II дугаар цэцэрлэгийн дунд хүүхэд хамгааллын сургалт орж 40 хүн хамрагдсан. Хүүхэд ба хариуцлагатай аав, ээж сургалтад хүүхэд хүмүүжлийн эерэг арга, харилцаа хандлага, хүүхэд хамгаалал, эцэг эхчүүд хүүхэдтэй тавих хараа хяналтаа сайжруулах, жендерийн эрх тэгш байдлын тухай сургалтыг орж нийт 302 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүн хамрагдсан. 2024 оны байдлаар гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 4 удаагийн сургалт, 2 нөлөөллийн ажлыг зохион байгуулж 418 иргэн хамрагдсан. Дээрх зөвлөмжүүдийг цахимаар тогтмол хүргэж байна. | |
| | 40 | Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана. | 2020-2024 | ЗДТГ, НБМ | | | “Аз жаргалтай гэр бүл-2" вакум сургалтыг зохион байгуулж тус сургалтад 2 залуу гэр бүл хамрагдаж сургалтаар “Сэтгэлийн холбоогоо бэхжүүлэх нь, харилцан ойлголцох урлаг, зөрчилдөөнийг шийдвэрлэх нь, гэр бүлийн нөлөө, хайрын 5 хэл, сэтгэлзүйн оношилгоо, хосын зөвлөгөө, зэрэг агуулгыг залуу гэр бүлүүдэд өгч 2 өдрийг бусад сумдын гэр бүлүүдтэй дурсамж дүүрэн өнгөрүүлсэн. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 18 дуудлага, цагдаагийн тасгаас гэр бүлийн хүчирхийллийн 8 дуудлага, илрүүлгийн 12 кейс нийт 38 кейс дээр ажиллаж хүүхэд, гэр бүлд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн байна. Хамгаалах байранд 9 ээж 21 хүүхдийг хамгаалах байрандаа хүлээн авч аюулгүй байдлыг ханган тэдэнд чиглэсэн хөгжил хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө нийт 98 иргэнд өгч мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөөнд 69 хүүхэд 18 иргэн хамрагдсан. | 100 |
| | 41 | Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна. | 2020-2024 | ЗДТГ, Хамтарсан баг | | Сургагч багш нараар дамжуулан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтад эцэг эхчүүдийг үе шаттай хамруулан, хандлагыг | Хүүхдийн эсрэг хүчирхийллийн “Үжин” төвтэй хамтран гэр бүлийн үнэ цэн, гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, гэр бүлийн харилцаа, эрүүл зөв амьдралын дадалд суралцах, хүүхдийн хөгжил, хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтыг 2 удаа зохион байгуулан 358 эцэг, эх, иргэн хамрагдсан. Мөн Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчилсөн байна | тогтвортой гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, угийн бичиг хөтлөхийн ач тус сургалтыг 7 удаа зохион байгуулан 429 иргэн хамрагдсан. Хүүхэд хамгаалал сургалтад сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 70 багш, “Хүүхэд ба хариуцлагатай аав, ээж”, “хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “харилцаа хандлага”, “хүүхэд хамгаалал, эцэг эхчүүд хүүхэдтэй тавих хараа хяналтаа сайжруулах”, жендерийн эрх тэгш байдлын тухай сургалтад нийт 382 иргэн хамруулсан. | |
| | 42 | Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хөдөөгийн залуучуудыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ, НБМ | | Хөдөөгийн 15-34 насны залуучуудад хүрч ажилласан байна. | Эрүүл мэндийн төвтэй хамтран өсвөр насны болон цэргийн насны залуучуудад БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, Архи согтууруулах ундаа, утаат болон электрон тамхины хор уршгийн талаар “эерэг хандлага ба хорт зуршил” сургалтыг 7 удаа зохион байгуулж нийт өсвөр насны 589 залууг хамруулсан. Бат-Өлзий сумын Социал Демократ Монголын Залуучуудын Холбоотой хамтран зохион байгуулсан “SDY CUP” спортын бага наадамд зургаан багийн 300 орчим залуучууд оролцсоноос 200 орчим нь хөдөөгийн залуус байсан. Мөн 1-6 дугаар багийн иргэдийн дунд “Миний нутаг сайхан” урлагийн бага наадмыг зохион байгуулж 80% нь 18-30 насны залуус хамрагдсан. Сумын залуучуудын холбоо, сагсан бөмбөгийн холбоо хамтран санаачилж иргэдийн хандиваар 100 жилийн ойг тохиолдуулан 3*3 сагсан бөмбөгийн гадна талбай байгуулан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин бүрдсэн. | 100 |
| ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОРИЛТУУД | | | | | | | | |
| Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж | 43 | Сумын иргэдийг урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн | 2020-2024 | ЭМТ | | | Эрт илрүүлэгийн үзлэгийг зорилтот насны ангиллаар анхан шатанд 0-17 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээг хөгжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн эмчилгээ үйлчилгээний хүртээмжийг сайжруулна | | үзлэгт хамрагдах хамрагдалтын хувийг 30%-д хүргэнэ | | | | | насны 2852 хүүхэд хамрагдахаас 1515 хүүхэд хамрагдсан. Үүнээс шүдний өвчлөл 32%-г эзэлж байна. Нийт хамрагдсан хүүхдийн 0,8% буюу 23 хүүхэд харааны өөрчлөлтэй, 1 хүүхэд цусны сахартай гэж оношлогдоод дээд шатлалд хүргэгдэн эмчлүүлж байна. 10 хүүхэд гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй,,цус багадалттай 5 хүүхэд жингийн алдагдалтай 6 хүүхэд байна. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй гэж оношлогдсон 10 хүүхдээс 5 хүүхдийг эмнэлэгт эмчлэн эрүүлжүүлсэн. 2 хүүхдийг дээд шатлалд илгээсэн.<br>Хөдөөгийн алслагдсан багаар явуулын амбулатори ажиллаж 300 гаруй хүүхдэд үзлэг хийж 0,9 сар-8 настай хүүхдүүдийг улаан бурхны нэмэлт дархлаажуулалтад хамруулсан. Нийт 1434 хүүхэд хамрагдахаас 788 буюу 58,8% нь хамрагдсан.<br>Цэцэрлэгийн насны 100 гаруй хүүхдэд амны хөндийн үзлэг хийж 72 хүүхэд шүдний цоорол өвчлөлтэй байснаас 21 нь шүдээ эмчлүүлсэн.<br>0-5 насны хүүхдүүдийг гэрийн эргэлтээр үзэж 220 хүүхдэд өндөр тунт А амин дэм 100 гаруй хүүхдэд Д амин дэм уулгасан. Онцгой хяналтад байдаг суурь эмгэгтэй 27 хүүхдийг хяналтын үзлэгт Өвөрхангай аймгийн БОЭТ рүү илгээсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх өдөрлөгт 8 хүүхдийг хамруулж тус хүүхдүүдэд А, Д амин дэм уулгав.<br>Урьдчилан сэргийлэх үзлэгт АГ- 527 иргэн ЧШ-561 иргэн ,Хөхний үзлэгт -656 иргэн, УХХ-82 иргэн тус тус хамрагдсан.<br>“Эрүүл монгол хүн” аяны хүрээнд УБ хотоос нарийн мэргэжлийн эмч нарын баг сумын төв болон Улаан-Ам багт 10 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийсэн. Сумын төвд давхацсан тоогоор 318 иргэн хамрагдсан. Үүнээс Дотор-86, хүүхэд-16, Зүрхний цахилгаан бичлэг-24, Мэдрэл-36, сэтгэц-10, Рентген-46, Нүд-42, ЧХХ-32, Шүд-26 иргэн. Үзлэгийн үр дүнд элэгний хавдар шинээр илэрч, зүрх судасны дутагдалтай 2 иргэний нэгийг дээд шатлалын байгууллагад илгээж, нэг иргэнийг сумын эмнэлэгт хэвтүүлэн эмчиллээ.<br>Улаан ам багт нийт давхацсан тоогоор 238 иргэн үзлэгт хамрагдсан. Үүнээс дотор 47, Хүүхэд 23, мэдрэл 21, сэтгэц 7, гэмтэл 18, шүд 39\ ломбо болон түрхлэг\, ЧХХ 23, Рентген 34, ЗЦБ 26 байсан.<br>2023 оны 07 сарын 01, 02 нд Өвөрхангай аймгийн БОЭТ-ийн Дотрын ЭХО, Нүд, Шүд, ЧХХ, Мэдрэл, Сэтгэц, Гэмтэл, Нөхөн сэргээх, уламжлалт, настны эмч нар ирж 230 ахмад настанд урьдчилан сэргийлэх үзлэг хийж эрүүл мэндийг үнэлж картжуулсан.<br>Амбулаторийн үзлэгт 5992 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 1483 хүн буюу 24,7 хувьтай хамрагдсан.<br>2024 онд сумын 100 жилийн ойн хүрээнд иргэдийн хандив тусламжаар Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн өрөөг 13.2 сая төгрөгөөр их бүрэн тохижуулсан.<br>-Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах зорилгоор зорилтот бүлгийн 3751 хүнд сургалт сурталчилгаа хийсэн.<br>-5-17 насны хүүхдийн эрт илрүүлэг 80 хувьтай, Насанд хүрэгчдийн эрт илрүүлэг 48 хувьтай байна.<br>-Урьдчилан сэргийлэх үзлэгт 1448 хүн хамрагдсан. | |
| | 44 | Эмч, мэргэжилтнүүдийг үе шаттайгаар сургаж | 2020-2024 | ЭМТ | | | 2020, 2021 онд 3 их эмчийг дотроор, 2022 онд 1 их эмчийг дүрс оношилгооны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жил бүр 3 хүртэл хүнийг сургалтад хамруулна. | | | | | нарийн мэргэжлийн эмчээр, 2023 онд хүүхдийн резидэнтээр 2 их эмчийг тус тус суралцуулж байна. | |
| | 45 | Орчин үеийн дэвшилтэт рентген аппараттай болгоно. | 2020-2024 | ЭМТ | | | 2024 онд Спирометри аппаратыг эмнэлэгт шинээр нэвтрүүлж гуурсан хоолойн багтраа, уушгины архаг бөглөрөлт өвчний оношилгоо шинжилгээг хийж байна. 25 хүнд спирометри оношилгоо хийсэн. | 70 |
| | 46 | Биохими болон шээсний анализатортай болгоно. | 2020-2024 | ЭМТ | | | 2021 оны 09 сард Биохими болон шээсний анализаторын аппараттай болсон. 2021 оны 11 сард ЭМТ-ийн лаборантыг “Биохимийн аппаратыг таниулан ажиллуулах” сургалтад хамруулсан. Биохимид Алат, Асат, Амилаза, Креатинин, Нийт биллурубин, шууд биллирубин гэсэн үзүүлэлтүүд үзэж байна. Биохими болон шээсний анализаторт хэвийн ажиллаж байна. Биохими болон шээсний анализатортой. 2024 онд 1430 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. | 100 |
| | 47 | Төвийн дуудлагын авто машинтай болгоно | 2020-2024 | ЗДТГ, ЭМТ | | | 2022 онд суудлын probox авто машин шийдэгдсэн. Орон нутгийн онцлог саад бэрхшээлээс болж түргэн тусламжийн үйл ажиллагаанд ашиглахад хүндрэлтэй байсан тул ЭМГ-ын даргын тушаалаар Зоонозийн өвчин судлалын фургон машинаар солилцоо хийж ашиглаж байна.<br>2023 онд суудлын Ланд 200 авто машиныг Эрүүл мэндийн төвд шийдэж өгсөн. | 100 |
| | 48 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор алсын дуудлагын авто машины парк шинэчлэлт хийнэ. | 2020-2024 | ЭМТ | | | 2021 онд орон нутгийн төсвөөс 6.300.000 төгрөгөөр авто машины парк шинэчлэл хийсэн. Мөн 2021 онд 2-р багийн эмчийг шинэ мотоциклтой болгосон. ЭМТ-өөс түргэн тусламжийн 2 автомашинд 2.500.000, мянган төгрөгийн засвар, 2023 онд ланд 200 маркийн авто машинд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 10,000.000 төгрөгийн засвар, 2024 онд 40,000,000 төгрөгийн засварыг улсын төсвөөр хийсэн. | |
| | 49 | Багийн эмч нарыг компьютер хэрэгслээр хангана. | 2020-2024 | ЭМТ | | | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3, 5 дугаар багийн эмч нарыг зөөврийн компьютероор хангасан.<br>2024 онд 1-5 дугаар багийн эмч нарыг Notebook болон модемтой болгосон. | 100 |
| | 50 | Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг шинээр барих. | 2020-2024 | ЗДТГ, ЭМТ | | 1 эмнэлэг шинээр баригдана | Эрүүл мэндийн төвийн 15 ортой эмнэлгийн өргөтгөл 1 тэрбум 356 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон. | 100 |
| | 51 | Эмчийн байрыг засварлах ба шинээр эмчийн байр барина. | 2020-2024 | ЗДТГ, ЭМТ | | | Эмчийн байранд дотор засвар хийж, Соёмбо зочид буудлын нэгдсэн халаалтад холбуулсан. | 70 |
| | 52 | Шүдний эмчтэй болох | 2020-2024 | ЗДТГ, ЭМТ | | | Шүдний эмчийг Өвөрхангай аймгийн “Мөнх-Ирээдүй” эмнэлэг, Улаанбаатар хотын “Ачтан” эмнэлгээс эмч нарыг дуудаж, түр хугацаагаар ажиллуулсан. Шүдний эмчээр сурч байгаа нутгийн оюутанд ажиллах саналыг хүргүүлж, орон нутагт ажиллахаар зөвшилцсөн.<br>Шүдний багаж, тоног төхөөрөмжийн тендерийг зарласан. | 70 |
| 2.2. БИЕИЙН ТАМИР | | | | | | | | |
| Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшил тогтоох, гэр бүлийг дэмжих, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ. | 53 | Иргэдийн дунд “Миний нутаг сайхан” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулна. | 2020-2024 | ЕБС БТАЗүйч | | | “Миний нутаг сайхан” спортын бага наадмыг 2 удаа 1-6 дугаар багийн иргэдийн дунд Үндэсний бөх, шатар, даам, шагайн харваа, үндэсний сурын харваа, теннис, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, дартс гэсэн спортын 10 төрлөөр зохион байгуулсан. Үүнд: 18-аас дээш насны 700 гаруй иргэн оролцсон. | 100 |
| | 54 | Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжин биеийн тамирын арга зүйчтэй болгоно. | 2020-2024 | | | | Биеийн тамирын арга зүйчийг Нийгмийн бодлогын мэргэжилтэн албан тушаалын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тодорхойлолтод заасны дагуу хариуцан гүйцэтгэж байна. | |
| | 55 | Өсвөр үеийг спортоор хичээллүүлэх ажлыг дэмжин жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, даам, цана, гар бөмбөг, сагсан бөмбөг, теннисний төрлүүдээр шигшээ баг бүрдүүлнэ. | 2020-2024 | ЕБС | | | 2021 онд Өсвөр үеийн жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, даам, цана, гар бөмбөг, сагсан бөмбөгийн төрлөөр секц, дугуйлан хичээллэсэн. Аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд 3 дугаар байр “Хүрэл медаль”, Үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд сурагч Д.Саранцогт 7 дугаар байранд, Үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байр, аймгийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 3 дугаар байр, 3 сурагч “Мөнгөн медаль” хүртсэн амжилтуудыг тус тус гаргасан.<br>2022 онд Аймгийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд 14 хүүхэд оролцсоноос 3 алт, 2 мөнгө, 9 хүрэл медаль хүртэж багаараа 2-р байр. Үндэсний бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж багаараа тэргүүн байр. Улсын аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд 2 хүүхэд амжилттай оролцсон.<br>2023 онд Монголын Биатлоны үндэсний шигшээ багийн тамирчин Д.Нямсүрэн Ганвон-2024 өвлийн олимпын наадамд оролцох эрх авсан.<br>Өвөрхангай аймагт болсон өсвөрийн үндэсний бөхийн тэмцээнд 28 хүүхэд оролцож багаараа тэргүүн байр эзэлж 3 алт, 3 хүрэл медаль, Чөлөөт бөхөөр 3 алт, 3 мөнгө, 8 хүрэл медаль, багаараа дэд байранд шалгарсан.<br>Хүүхдийн спортын 7 дугаар их наадамд цанын төрлөөр 13 хүүхэд оролцож 6 алт, 2 мөнгө, 20 хүрэл медаль хүртсэн.<br>Өвөрхангай аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 92 жилийн ойн баяр наадмаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өсвөрийн 32 бөх барилдсанаас 11б ангийн сурагч М.Ганбаяр үзүүрлэсэн. Улсын өсвөрийн сурын эрэгтэй харвааны төрөлд 11в ангийн сурагч Ч.Түвшинжаргал гуравдугаар байр, 8в ангийн сурагч Ч.Цэндсүрэн аймгийн ИДЭР МЭРГЭН цолны болзол хангаж, Булган аймгийн баяр наадамд тэргүүн байр, Налайх дүүргийн баяр наадамд тэргүүн байр эзэлсэн, 9б ангийн сурагч Хонгорзул дэд байр, 4б ангийн сурагч Г.Дөлгөөнжаргал 5 дугаар байр эзэлсэн. Арвайхээр суманд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын 7 дугаар их наадмын анхан шатны өсвөрийн аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнд анх удаагаа оролцож багийн төрөлд 10в ангийн сурагч Ө.Өсөхбаяр ахлагчтай баг тамирчид гутгаар байр, Ганцаарчилсан төрөлд 10в ангийн сурагч Ө.Өсөхбаяр тусгай байр, 6 сард зохион байгуулагдах Хүүхдийн спортын 7 дугаар их наадамд аймгаа төлөөлөн оролцсон.<br>"Өсвөрийн шатарчдын Улсын аварга" шалгаруулах хөвгүүдийн 54, охидын 48 дахь удаагийн шигшээ тэмцээн - 2023" 4 сарын 1-5 өдөр зохион байгуулагдаж сургуулиас эрэгтэй 14 насны ангилалд 7в ангийн сурагч Б.Бямбадорж, 8в ангийн сурагч Б.Энхбаяр, эмэгтэй 14 насны ангилалд 8в ангийн сурагч П.Энхтуяа нар амжилттай оролцож хувь, рейтингээ ахиулсан.<br>"ИРЭЭДҮЙН АВАРГА " үндэсний бөхийн барилдаанд сургуулиас 8 сурагч оролцож 10а ангийн сурагч Д.Ган-Эрдэнэ 2 дугаар байр, 11в ангийн сурагч Т.Ням-Очир 3 дугаар байр, 11в ангийн сурагч Д.Наранцогт 4 дүгээр байранд тус тус шалгарсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хүүхдийн спортын наадмын анхан шатны ХӨНГӨН АТЛЕТИКИЙН аймгийн аварга шалгаруулах тэмцээний задгай төрөлд 12 сурагч, 4 төрөлтөд 8 сурагч оролцож 6 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн. Сагсан бөмбөг, гар бөмбөгийн секц дугуйланд 60 хүүхдийг тогтмол хичээллүүлж шигшээ баг бүрдүүлж тэмцээн уралдаанд оролцож байна. 2024 онд Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь шатрын спортын дэд мастер Д.Дуламдоржийн агсны нэрэмжит шатрын кабинеттай болсон. | |
| | 56 | Жил бүр спортын нэрэмжит тэмцээнүүдийг зохион байгуулна | 2020-2024 | ЗДТГ ЕБС | | | Жил бүр уламжлал болгон сургууль цэцэрлэгийн эцэг эхийн нэрэмжит волейболын тэмцээнийг зохион байгуулдаг бөгөөд, баг бүр шагналын боосоогоо хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд зарцуулдаг. Мөн төгсөгчид, залуучууд, ойн нөхөрлөлүүдийн нэрэмжит сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээн жил бүр зохион байгуулагдаж байна. Мөн байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдаа хамруулан спортын уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж байна. | 100 |
| | 57 | Сумын хүний хөгжлийн индексийн үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргана. | 2020-2024 | Статистик хариуцсан мэргэжил тэн | | | Хүний хөгжлийн индексийг аймаг, сумын хэмжээнд гаргах аргачлал байхгүй. Аймгийн хэмжээний хүний хөгжлийн индексийг улсаас гаргаж өгдөг. | - |
| | 58 | Хөл бөмбөгийн талбайтай болох | 2020-2024 | ЗДТГ, Багийн захиргаа | | | 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөж, тендер зарлагдан, санхүүжилт хүрэлцэхгүйн улмаар тендер шалгаруулалт хүчингүй болсон. | 30 |
| **2.3. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БОДЛОГО ЗОРИЛТУУД.** | | | | | | | | |
| Зорилт 1. Багш сурагчдын сурч, хөгжих орчныг | 59 | Суманд 440 хүүхдийн сургуулийн барилга шинээр барина. | 2020-2024 | ЗДТГ, ЕБС | 5,3 тэр бум | 1 | 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 440 хүүхдийн сургууль | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| сайжруулан, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | шинээр барьж улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон. | |
| | 60 | 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барина | 2020-2024 | ЗДТГ, ЕБС | 1,2 тэр бум | 1 | 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил дуусаж улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон. | 100 |
| | 61 | Сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ. | 2020-2024 | ЗДТГ, ЕБС | | | Улсын төсвийн хөрөнгөөр 80 хүүхдийн дотуур байранд 70 сая төгрөгийн төсөвтэй их засварын ажлыг “Хүүшийн гэгээ” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. | 100 |
| | 62 | Багш хөгжлийн төвийг ширээ, сандалтай болгох. | 2020-2024 | ЕБС | 1,885,000 | | 2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар химийн кабинетыг лабораторийн 70 нэр төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан.<br>2021 онд БСШУЯамны санхүүжилтээр хичээлийн иж бүрэн хэрэглэгдэхүүн сандал ширээгээр ханган Эко кабинеттай болсон.<br>2022 онд 89.910.000 2023 онд 79.450.000 төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг мэдээлэл зүйн танхим болон цахим сургалтын танхимд зарцуулсан. Үүнд: суурин компьютер 10 ширхэг 29,530,000 төгрөг, Таблет-55ш, суурин компьютер-7ш, веб камер-2ш, зөөврийн компьютер-6ш, ухаалаг самбар-2ш, утасгүй сүлжээний төхөөрөмж-1ш, chromebook 20ш<br>2023 онд мэдээлэл зүйн танхимд 25 ширээ 5.500.000 төгрөг, шилэн кабель, рүүтер 1.474.000 төгрөгийг тус тус байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас.<br>2024 онд Багш нарын ажиллах орчныг сайжруулах, тав тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн багш хөгжлийн 2 танхимыг тохижуулсан. | 100 |
| | 63 | Хими, мэдээлэл зүйн, биологийн иж бүрэн кабинеттай болгоно. | 2020-2024 | ЕБС | 12,194,380 | 2 | 2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар химийн кабинетыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | лабораторийн 70 нэр төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан. 2021 онд БСШУЯамны санхүүжилтээр хичээлийн иж бүрэн хэрэглэхүүн сандал ширээгээр хангагдан Эко кабинеттай болсон. Мэдээлэл зүйн танхимд 2023 онд 25 ширээ 5.500.000 төгрөг, шилэн кабель, рүүтер 1.474.000 төгрөгийг тус тус байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас, суурин компьютер 10 ширхэг 29,530,000 төгрөгөөр худалдан авсан. Улсын төсөв /нөхөн хангалтын зардлаар/ Цахим кабинет шинээр байгуулж байгуулсан Үүнд Таблет-55ш, суурин компьютер-7ш, ухаалаг самбар-2ш, утасгүй төхөөрөмж-1ш нийт 89,910,000 төгрөгөөр Улсын төсөв /сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар/ | |
| | 64 | ЕБС, 1 дүгээр Цэцэрлэгийн камержуулалтыг орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камертай болгоно | 2020-2024 | ЕБС | 9,500,000 | | Сургуулийн 2 хичээлийн байр, 2 дотуур байрны гадна дотор талд орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камерыг суурилуулсан. “Хос задь” хариуцлагатай хувьцаат компани нь ажил гүйцэтгэх гэрээгээр хичээлийн 2-р байрны гадна 3 ширхэг, дотор 13 ширхэг хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжийн хамт суурилуулахад 5.200.000 төгрөг, 80 хүүхдийн дотуур байр хичээлийн 1-р байрны камер засварт 1.370.000 төгрөг тус тус зарцуулсан. Камер хяналтын журмыг мөрдөн ажиллаж байна. Хичээлийн 1 дүгээр байрны спорт заал, анги танхимын камерын зардалд 6,200,000 төгрөг шаардлагатай байна. 2021 оны 08 дугаар сард БСУГ-аас цэцэрлэгийн гадна 3 камер, дотор 13 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ширхэг орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын нийт 16 камер ирсэн уг камерыг Өвөрхангай аймгаас мэргэжлийн хүн авчирч суурилуулан камерын бичлэгийг тогтмол хянаж байна. | |
| | 65 | ЕБС-д сэтгэл зүйчийн орон тоог бий болгоно. Мэргэшсэн сэтгэл зүйчээр хангана. | 2020-2024 | ЕБС | | | 2023 оны 03 дугаар сарын 01-ээс эхлэн ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн ба мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан ажиллаж байна.<br>2024 оны 09 дүгээр сарын 02-оос эхлэн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн. | 100 |
| | 66 | ЕБС, СӨББ-уудыг хөгжим, техник хэрэгслээр бүрэн хангана. | 2020-2024 | ЕБС, СӨББ-ууд | 3,036,800 | | 2021 онд ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн кабинетад чанга яригч пульт /YAMAHA/, мөн укулули хөгжим 5 ширхэг тус тус өгсөн. Одоо чадал, даралтат хөгжим шаардлагатай байна. СӨББ-ын хөгжим техник хэрэгсэлтэй болох хүсэлтийг УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн.<br>2024 онд Борын Ламзав агсны ач, зээ нараас Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 18.620.000 төгрөгийн үнэ бүхий цахилгаан хөгжмийн багц, өсгөгч, пульт, чадал зэргийг хандивласан. | 90 |
| | 67 | СӨББ-уудыг 2 ээлжийн зөөлөн эдлэлээр хангана | 2020-2024 | СӨББ-ууд | | | 1 дүгээр Цэцэрлэгт 50 ш, 2 дугаар Цэцэрлэгт 20 ш зөөлөн эдлэлийг Тайваны хүүхдийг ивээх сангаас нийлүүлсэн. | 100 |
| | 68 | 1 дүгээр Цэцэрлэгийн хуучин байрны сантехникийг шинэчлэх. | 2020-2024 | СӨББ | | | 1 дүгээр цэцэрлэгийн хуучин байрны сантехникийг шинэчлэх ажлын тендер 2 удаа зарлагдсан боловч нэг ч аж ахуйн нэгж ороогүй. | 50 |
| | 69 | 1 дүгээр Цэцэрлэгийн цэвэр бохир усны сантехникийн асуудлыг шийдвэрлэнэ. | 2020-2024 | СӨББ | | | 2020 оны 08.01-08.28-ны хооронд Улсын төсвийн 62.0 сая төгрөгийн цэвэр, бохир усны их засварыг “Чусан” ХХК-нь цэцэрлэгийн барилгын гадна талын 766 м2 пассат, 10 бүлэгт 20-н суултуур, 22 угаалтуур, 4-н ванн, гал тогоонд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | угаалтуур, цэвэр усны нөөцийн сав, цэвэр бохир усны шугамыг бүрэн шинэчлэн их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2021 онд улсын төсвийн 8,0 сая төгрөгийн хөрөнгөөр дээврийн засварыг “Санги констракшн” ХХК гүйцэтгэсэн. | |
| | 70 | СӨББ-уудыг хүүхдийн стандартад нийцсэн тоглоом наадгайгаар хангана. | 2020-2024 | СӨББ | | | Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сангаас 2021 онд Японы хандиваар хүүхдийг тоглоом сургалтын хэрэглэгдэхүүнийг олгосон. Үүнд: Цагаан хэрэглэл 30 ш, хөнжил гудас 30 ш, хүүхдийн машин 6, мөлхөлтийн саад 6, соронзтой тоглоом 5, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом 2, эвлүүлдэг тоглоом 5, цифр нүдлэх тоглоом 5ш, авиралтын шат 2, хайс 2ш.<br>Гадна тоглоомын талбайд хүүхдийн эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжсэн орчин бүрдүүлэн, байгууллагын хөрөнгөөр будаж засвар хийсэн.<br>2021 онд багш ажилчид иргэдийн дэмжлэгтэй гадна тоглоомын талбайд 7.000.000 /долоон сая/ төгрөгийн тоглоомтой болсон. | 100 |
| | 71 | Хүүхэд бүрийг сургуульд тэгш хамруулах боловсролын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь”, “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслүүдийг хамтран хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЕБС хамтарсан баг | | | 3 дахь жилдээ хэрэгжиж буй орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол олгох төслийн хүрээнд хаврын ангийн төгсөлтийн 2 дугаар шатны төслийн шалгаруулалт амжилттай явагдсан. PITCH-EVENT-2 оролцсон 10 төслөөс: -Scientists багийн " Мини фото студи" төсөл /чиглүүлэгч багш: нийгмийн ажилтан Б.Бямбадорж/,<br>-"Green project" /чиглүүлэгч: нийгмийн ухааны багш Ж.Доржханд/<br>-Teen journalist багийн "Сурагч сэтгүүл" төсөл<br>-Оюунлаг багийн "Уран бийр сургалт, захиалгат үйлчилгээ"төсөл /чиглүүлэгч: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | МХУЗ-ын багш Б.Даваажав/ ISPN багийн "Guide club" / чиглүүлэгч: англи хэлний багш Ч.Сувд-Эрдэнэ/ зэрэг төслүүд тус тус шалгарсан. Аймгийн шалгаруулалтад 5 төсөл дэмжигдээд улсын шалгаруулалтад 3 төсөл шалгаран санхүүжилтээ аван үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны 06 сарын 15 нд төсөлд хамрагдсан сурагчдын эцэг эхчүүдэд төсөлтэй холбоотой мэдээ, мэдээлэл өгч чиглүүлэгч багш нар төслийн сургалтын явцад хүүхдэд гарсан үр дүнгийн талаар тайлагнасан. 11 сарын 03-нд Хархорин суманд зохион байгуулагдсан Хангайн бүсийн чуулга уулзалтад чиглүүлэгч багш нар, төсөлд хамрагдаж буй сурагчид нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй оролцож туршлага судалсан.<br>2022-2023 оны хичээлийн жилд намрын 2 ангид 48 сурагч хамрагдаж PITCH-5 үйл ажиллагаанаас "Солонго", "Жүжгийн дугуйлан", "Book cafe" төслүүд амжилттай шалгаран 8.400.000 төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Өсвөрийн энтрепренер клубүүдийн "LEADERS OF NEW CENTURY" чуулга уулзалт 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Арвайхээр хотод зохион байгуулсан. Уг уулзалтаар манай сургуулийн Leadership club "Гадагшаа чиглэсэн шилдэг үйл ажиллагаа"-тай клубээр шалгарсан. 2023 оны 8 сарын 12-21-ний өдрүүдэд ОЛОН УЛСЫН НАЙРАМДАЛ зуслан дээр зохион байгуулагдсан "Үндэсний туршлага солилцох уулзалтад" нийгмийн ажилтан Л.Золжаргал Өвөрхангай аймгаа төлөөлөн оролцсон. Уг уулзалтад 11б ангийн сурагч Э.Отгонболд, 12б ангийн сурагч Т.Оюунболор нар сургуулиа | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөөлөн оролцсон. 2023-2024 оны хичээлийн жилийн намрын элсэлтэд ЕБС-ийн 2 ангид 48 сурагч НТБН-ийн хосолсон ангид 14-25 насны 20 залуучууд хамрагдаж байна. Төслөөс сургалтад шаардлагатай олон үйлдэлт принтер, Tablet зэрэг хичээлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг өгсөн. | |
| | 72 | Уламжлалт монгол ахуй, өв соёлоо сэргээн хөгжүүлэх зорилгоор угийн бичиг хөтлөх, монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2020-2024 | Соёлын төв, ЕБС, ЗДТГ | | | 2022 онд “Угийн бичгээ бичиж хэвшье” аяныг зохион байгуулж, нийт 15 бүлгийн 385 сурагч,125 багш, ажилтан, албан хаагчид хамрагдсан. Үүнд: 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд угийн бичгээ хэрхэн хөтлөх вэ? - сургалтыг зохион байгуулж, жишиг даалгаврын хүрээнд аав ээжтэйгээ хамтарч угийн бичгээ хөтлөх ажлыг эхлүүлсэн. Доорх 8 сэдвийн хүрээнд нийт 377 сурагчдаар эсээ бичүүлсэн.<br>➢ Зөв сэтгэлийн ач тус, буруу сэтгэлийн хорыг ухаарах<br>➢ Эх оронч үзэлтэй байх нь ямар чухал болох<br>➢ Өв соёлоо эрхэмлэх, эх оронч сэтгэлгээ<br>➢ Ёс заншил, монгол ахуйгаа таньж мэдэх<br>➢ Уламжлалт ёс, өв соёлоо хүндэлж хамгаалдаг байх<br>➢ Бие, хэл, сэтгэлээр үйлдэх сайн үйлүүд<br>➢ Гэр бүл, анги хамт олон, бусад хүний болон нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа сайтар ухамсарлах<br>➢ Эв эетэй байх<br>“Үндэсний бичиг III” хөтөлбөрийн хүрээнд төрийн Ерөнхий боловсролын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | монгол хэл, уран зохиолын 8 багш 5 байгууллагын 150 албан хаагчдад үндэсний бичгийг заасан. Албан байгууллагуудад мэдээлэл хүргэж, хөтөлбөрийн зорилго чиглэлийг танилцуулан ажилчдаас унших, бичих чадвараар гараа тогтоож сургалтаа эхэлсэн.<br>Үүнээс анхлан суралцагчдын гараа 30%-тай байна. Үүнээс үүдэж 2 бүлэгт хуваан 7 хоногт нэг нэг удаа орсон.<br>Бүлэг 1: Унших бичих чадвар сайн учир групп чат үүсгэж мэдээлэл болон уншиж, бичих даалгавар байршуулж, хүнд гаргахгүй үгсээ асууж ярилцаж байв. Танхимаар орохдоо зөвхөн хичээнгүй бичиг заалгах сонирхолтой хүмүүс сууж, бичгийн хэвээ сайжруулах зорилгоор суралцсан.<br>Бүлэг 2: Анхлан суралцах шаардлагатай 45 хүнийг хамрууллаа. Эдгээр суралцагч нар 7 хоногийн 3 дахь өдөр бүр 17-19 цагийн хооронд хичээллэсэн.<br>2023 онд төрийн албан хаагчдын үндэсний бичгийн гарааг цахим сорил аван тогтоосон. Сурагчдын амралтаар ЕБС-ийн багш нарт үндэсний бичгийн даалгавар өгч ажиллуулан шалгалт авсан. | |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 3.1. **Төрийн үйлчилгээ.** | | | | | | | | |
| Зорилт: Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй, ёс зүйн | 73 | Төрийн захиргааны байгууллагат чиг үүргийн шинжилгээ хийж давхардал, хийдлийг арилган бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно. | 2020-2024 | ЗДТГ | | | Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээг Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй хамтран хийж гүйцэтгэн, ажлын хийдэл, давхардлыг арилгаж, аймгийн Засаг даргын захирамжаар орон тоог шинэчлэн баталж, Засаг даргын Тамгын газрын үндсэн орон тоонд 23 албан хаагч ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| алдаа гаргасан албан хаагчдад хариуцлага тооцож, төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 74 | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн сан бүрдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | | Албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тушаалын 7 дугаар хавсралтын аргачлалын дагуу ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчдийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур үзүүлэлт болгон үнэлэн дүгнэж, мэдээллийн сан бүрдүүлж ажилласан. 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр 11,232,000 төгрөгийн урамшуулал олгосон. | 100 |
| | 75 | Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагат ил тод, нээлттэй болгоно. | 2020-2024 | ЗДТГ | | 4 | Төрийн албаны сонгон шалгаруулалтад удирдах албан тушаалтны -4, гүйцэтгэх албан тушаалтны-6, нийт 10 сул орон тооны мэдээлэл, төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага ёс зүйтэй холбоотой мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас csc.gov.mn болон сумын цахим хуудас Bat-Ulzii.ov.gov.mn, мэдээллийн самбаруудаар мэдээлсэн. | 100 |
| | 76 | Нэг цэгийн үйлчилгээг стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. /ширээ, сандал/ | 2020-2024 | ЗДТГ | ОНХС 40,0 сая | | 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Нэг цэгийн үйлчилгээг стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангасан. Үүнд: Киоск, ТҮЦ машин 1, стандартад нийцсэн ширээ сандал, бусад тавилга эд хогшил. Аймгийн төсвөөс Гэрэгэ буюу лавлагааны мөнгө тушаадаг коиск машинтай болсон. | 100 |
| | 77 | ЗДТГ-ын барилга шинээр барих. | 2020-2024 | ЗДТГ | 320,0 сая | | ЗДТГ-ын барилгын их засварын ажил 250,0 сая төгрөгөөр хийгдэж 2021 онд ашиглалтад орсон. Мөн 70,0 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмжөөр хангагдсан. 2024 онд 20 сая төгрөгөөр сантехникийн засвар, 40 сая төгрөгөөр дотоод засвар хийсэн. | 100 |
| | 78 | ЗДТГ-ын урд талбайг тохижуулах, машины зогсоол шинээр барих. | 2020-2024 | ЗДТГ | | | Засаг даргын Тамгын газрын урд талбайг засварлаж, тохижуулсан. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 79 | ЗДТГ үйлчилгээний авто машинтай болох. /8-12 хүний суудалтай/ | 2020-2024 | ЗДТГ | | | Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хойшлогдсон. | - |
| | 80 | Дөрвөн машины багтаамжтай гарааш барих. | 2020-2024 | ЗДТГ | | | Дөрвөн машины багтаамжтай гарааш бари ажил 2025 оны төсөвт тусгагдсан. | 50 |
| | 81 | Шинэ ковштой болох. | 2020-2024 | ЗДТГ | | | Байгальд орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрт төлбөр төлөгч иргэнээс ШШГХ-ээр шийдвэрлүүлэн ирсэн иргэнээс 176,700,000 төгрөгийн өртөг бүхий уул уурхайн зориулалттай ковштой машинтай болсон. | 100 |
| | 82 | Багийн Засаг дарга нарыг компьютер, ширээ сандлаар хангах. | 2020-2024 | ЗДТГ | 16,8 | Тоног төхөөрөм жийг шинэчлэх | Багийн Засаг дарга нарыг Орон нутгийн төсвийн 16,8 сая төгрөгийн санхүүжилтээр компьютер, техник хэрэгсэл, сейф, ширээ, сандлаар бүрэн хангасан. | 100 |
| **3.2. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ** | | | | | | | | |
| | 83 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно. | 2020-2024 | ЗДТГ | | | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тодотгол хийж, томилгоот 158 иргэнийг томилгоожуулж, үүрэг гүйцэтгэх, дадлага олгох сургалтыг 2021 оны 09 сарын 15-аас 19-ны хооронд Цэргийн штабтай хамтран 1 нэгжийн 30 үүрэгтнийг 256 дугаар цэргийн анги дээр бэлтгэл сургалтад хамруулсан.<br>2022 оны 9 дүгээр сарын 6-13-ны өдрүүдэд Цэргийн штабаас зохион байгуулсан "Дэг журам сахиулахад дэмжлэг үзүүлэх салаа"-ны 30 иргэнийг Орон нутгийн хамгаалалтын Хангайн бүсийн сургалтад оролцож "Бүрэн хангалттай" гэсэн үнэлгээг Батлан хамгаалахын сайдаас авсан. | 100 |
| | 84 | Ерөнхий боловсролын бүх сургуулиудад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол хугацаанд хэрэгжүүлж, сумын цэрэг-эх орны | 2020-2024 | ЗДТГ, ЕБС | | | Хүүхэд, залуучуудын дунд цэрэг-эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх сургалт хичээлийг ЕБС-тай хамтран зохион байгуулж, жил бүр ахлах ангийн сурагчдын дунд "Дөл" тоглолтыг 5 дугаар сард зохион байгуулж хэвшсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэдэвт хөшөө, дурсгалын зүйл, бодит түүхийн ой санамжийг сэргээх, илэрхийлэх санал санаачилгуудыг дэмжиж ажиллана. | | | | | Хүүхэд залуучуудыг цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, сурталчлан таниулах зорилгоор Я.Нармандахын санаачилгыг дэмжиж Монгол Улсын баатар Ардын хувьсгалын партизан Жигмэдийн Чулууны нэрэмжит “Эх орончдын танхим”-ыг Соёлын төвд байгуулсан. | |
| | 85 | Сумын гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг аюулын төрөл бүрээр эрх бүхий байгууллагаар хийлгэнэ. | 2020-2024 | ЗДТГ | | | 2024 онд гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг “ДИ ӨҮ ЭЙ ЭС” ХХК-аар хийлгүүлсэн. Төсөвт өртөг 20,0 сая төгрөг. | 100 |
| | 86 | Сумын гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, зарим тоног төхөөрөмжөөр хангана. | 2020-2024 | ЗДТГ | | | 2023 оны 06 дугаар сарын 08-нд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг цахимаар зохион байгуулж, Онцгой комисс, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулан сургалтыг зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах команд штабын иж бүрэн сургуулийг 2023 оны 10 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд зохион байгуулж, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг Онцгой байдлын албан хаагчидтай хамтран чадавхжуулах сургуулилтыг зохион байгуулж, шаардлагатай багаж хэрэгслийг нэмэгдүүлсэн. | 100 |
| **ДӨРӨВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | | |
| | 87 | “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | 2020-2024 | Цагдаагийн тасаг | | | Цагдаагийн тасагт иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэрэг зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл нийт 186-ийг хүлээн авч, үүнээс гэмт хэргийн шинжтэй 37 гомдол мэдээлэл, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 149-ийг хүлээн авч, зөрчлийн хэрэг нээж, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан. Үүнээс: гэмт хэргийн шинжтэй 20-н гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Архи согтуууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 89 иргэнийг Хархорин сум дахь сум дундын шүүхээс жолоодох эрх хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний 400.000 төгрөгөөр **/35.600.000 төгрөг/** торгосон байна. Эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 38 иргэнд 15.600.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Замын хөдөлгөөний журам зөрчсөн 1125 иргэнд **24.391.000** төгрөгийн бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлж Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд тавигдсан видео, шторк, бусад мэдээллийг хэрэгжүүлэх талаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>“Хулгайлах” гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх чиглэлээр цагдаагийн тасгийн алба хаагч нар 25 удаагийн өргөтгөсөн эргүүл шалгалтад цагийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж тээврийн хэрэгслийн тээш, зорчигч нарт үзлэг шалгалтыг хийж ажилласан.<br>Суманд архидан согтуурах явдалтай тэмцэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, сумын нөхцөл байдлыг бодит байдлаар гаргах зорилгоор иргэд, байгууллагаас ирсэн архидан согтуурсан дуудлага мэдээлэл бүрийг бүртгэн шалгаж гэмт буруутай этгээдүүдэд хариуцлага тооцон ажиллаж байна.<br>Сумын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | салбар зөвлөлөөс тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах орон тооны бус зөвлөл байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төрийн байгууллагын алба хаагчид Засаг даргын тамгын газрын алба хаагчид, цагдаагийн тасгийн алба хаагчид хамтран олон нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаа хуваарийг батлуулан ажиллаж байна.<br>Сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч хүүхэд багачуудад гэмт хэрэг зөрчлийн талаар ойлголт өгөх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн талаар, экологийн цагдаагийн албаны чиглэлээр сургалтуудыг давхардсан тоогоор нийт 10 удаа зохион байгуулж ажилласан.<br>Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуульд “Эко бүлгэм” байгуулж, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд 9-12 дугаар ангийн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгуулан ажилласан.<br>“Эко бүлгэм”-ийн хүүхдүүдтэй хамтран “Хүйтэн булга”ийн ойр орчимд хог хаягдал цэвэрлэж ажилласан. | |
| | 88 | Архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийллийг | 2020-2024 | Цагдаагийн тасаг | | | Архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ ар гэртээ агсан согтуу | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүчирхийллээс хамгаалах байр барих. | | | | | тавьж, гэр бүл, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 68 иргэнийг Хархорин сум дахь сум дундын шүүхээр 7-30 хоног баривчлуулсан.<br>Архидан согтуурсан үедээ өөрийгөө удирдан авч явах чадваргүй болсон 87 иргэнийг ар гэр, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгсөн. Сумын Засаг даргаар захирамж гаргуулан "Нийтийн эргүүл"-ийн хуваарь гаргаж иргэдэд хууль сурталчлах, иргэдийг олноор хамруулах ажлыг зохион байгуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл шалгалтыг зохион байгуулж ажиллаж байна.<br>Хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага тус бүр дээр анхаарал хандуулан тухайн асуудлыг хуулийн хүрээнд тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын байранд шаардлагатай зөөлөн эдлэл, цахилгаан хэрэгсэл 3,000,000 төгрөгөөр худалдан авсан. | |
| | 89 | Гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Цагдаагийн тасаг | | | Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлж Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд тавигдсан видео, шторк, бусад мэдээллийг хэрэгжүүлэх талаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>"Аажуу явбал аяндаа хүрнэ дээ", "Улсын дугаар" , "Хамгаалах малгай", "Торгууль нөхөн төлүүлэлт", "Мотоцикл", "Хичээл эхэллээ" , "Галт зэвсэг", "Мал мах", "Хүн бүр байгаль хамгаалагч", Эко-2024", "Бодис", "1 тэрбум мод" , "Хянамгай байя" , "Хар цэг", "Бүртгэл хяналт" нэгдсэн арга | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээг хариуцсан сумандаа үр дүнтэй зохион байгуулж ажилласан.<br>Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн тасгийн албан хаагч нар 450 удаагийн өргөтгөсөн эргүүл шалгалтад цагийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж тээврийн хэрэгслийн тээш, зорчигч нарт үзлэг шалгалтыг хийж ажилласан.<br>Баасан гарагт цаг хэтрүүлэн ажиллаж байсан 8 цэгийн үйл ажиллагааг зогсоож цагийн хуваарийг баримтлан ажиллах талаар сануулж ажилласан. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий цэгүүдэд Архигүй орчин аяны хүрээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий 46 цэгт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих/ 6.5.11.11.2,113,11.4,11.5,13. / заалт, аймгийн Засаг даргын тоот захирамжаар зөвлөмж боловсруулан хуулийн буланд байршуулж сурталчилсан. | |
| | 90 | Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах цогц арга хэмжээ авах. | 2020-2024 | Цагдаагийн тасаг | | | Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 1,2,3,4,5,6 дугаар багийн малчдын зөвлөгөөн зохион байгуулан малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, зөвлөгөөг өгч , хариуцсан баг тус бүрд малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий малчны бүлэг байгуулж, иргэд малчдад малын хулгайн гэмт хэргийн талаар үнэн бодит мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулж мэдээллийг чандлан нууцлах талаар малчдад ойлгуулж мэдээлэл хийж сумын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | олон дагагчтай цахим хаягуудад гарал үүсэлгүй мал, мах тээвэрлэхэд Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ тооцуулах талаарх мэдээллийг түгээж малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлгийг байршуулан зөвлөгөө өгч хяналт тавьж ажилласан. Мөн мал хулгайлах гэмт хэргийг хийж байж болзошгүй нэг иргэнийг илрүүлэн хяналтад авч ажиллаж байна.<br><br>Өвөрхангай аймаг Бат-Өлзий сумын 1.2.3.4.5.6 дугаар багийн малчдын зөвлөгөөн болсон холбогдуулан мал хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, зөвлөгөөг өгч, хариуцсан баг тус бүр малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий малчны бүлэг байгуулж, иргэд малчдад малын хулгайн гэмт хэргийн талаар үнэн бодит мэдээлэл өгсөн иргэний урамшуулж мэдээллийг чандлан нууцлах талаар малчдад ойлгуулж мэдээлэл хийж, сумын олон дагагчтай цахим хаягуудад гарал үүсэлгүй мал, мах тээвэрлэхэд Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ тооцуулах талаарх мэдээллийг түгээж, хүн олон цуглардаг газруудад малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлгийг байршуулан, Өвт 5 дугаар багт "Өвт Хайрхан" нэртэй 12 хүний бүрэлдэхүүнтэй малчны бүлэг, Сөдтий 2 дугаар багт Билүүт гэх газар "Тархинт" гэсэн нэртэй 8 хүний бүрэлдэхүүнтэй малчны бүлэг байгуулан ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 91 | Цагдаагийн кабон байрны урсгал засварыг хийх. | 2020-2024 | Цагдаагийн тасаг | | | 2023 онд цагдаагийн кабон байрны урсгал засварыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| **Тав.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | | |
| | 92 | Халдварт цар тахлын үед нийгмийн хамгааллын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ. | 2021 | Онцгой комисс | | | Сумын Онцгой комисс халдварт цар тахлын үед авах арга хэмжээний талаар 27 удаа хуралдаж, тухай бүр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан. | 100% |
| | 93 | Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана | 2021 | Сумын Онцгой комисс | | | Ихаламж системд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 388 иргэний хүсэлтийг бүртгэж тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийг бүртгэж илгээсэн байна. Үүнээс авч үзэхэд тэтгэвэрт -12 иргэн, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид -55 иргэн, жирэмсэн эхийн тэтгэмжид -58 иргэн, цалинтай ээжийн тэтгэмжид -66 иргэн, өрх толгойлсон эхийн мөнгөн тэтгэмжид 2 иргэн, насны хишигт -48 иргэн, хүүхдийн мөнгөн тэтгэмжид -65 иргэн, ахмад настны хиймэл шүдний хөнгөлөлтөд -15 иргэн, рашаан сувилалын хөнгөлөлт -23 иргэн, замын зардлын хөнгөлөлтөд 2 иргэн, эрхийн бичгийн хөнгөлөлтөөр 20 иргэн, ахмадын хүндэтгэлд -7 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хиймэл шүдний хөнгөлөлтөд -1 иргэн, ХБХ-ийн согог засах гутал 1 иргэн, сонсголын аппарат 1 иргэн, ХБИ-ний рашаан сувилалын хөнгөлөлтөд 9 иргэн, харилцаа холбооны хөнгөлөлтөд 2 иргэн хамрагдсан. | 100% |
| | 94 | Цар тахлын үед түлээ, нүүрс, хүнсний хомсдолд орж болзошгүй иргэдэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч, дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | 2021 | Онцгой комисс | | | Нийгмийн халамжийн сангаас тэжээн тэтгэх төрүүлсэн үр хүүхэдгүй, ганц бие 7 ахмад настанд түлшний хөнгөлөлт 980000 төгрөг, 80 хувиас дээш хөдөлмөрийн чадвараа алдсан байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хууль журмын дагуу нийт 50 иргэнд 7.000.000 төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгосон. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 95 | Түлээ, нүүрс, хүнс, шатахуун зэрэг өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, тараалт, борлуулалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, үнийн өсөлт үүсэхээс сэргийлж ажиллана. | 2021 | Онцгой комисс | | | Түлээ, нүүрс, хүнс, шатахуун, эм зэрэг өргөн хэрэглээний барааны үнийг тогтвортой байлгах, үнийн хөөргөдөл үүсгэхгүй байх талаар сумын Засаг даргын захирамж гарган хэрэгжилтийг хянан ажилласан. | 100% |
| | 96 | Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулна | 2021 | Онцгой комисс | | Аж ахуй нэгжийн тоо 144 | 154 аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх зөвлөгөө, мэдээллийг facebook, group, цахим орчин, мэдээллийн хэрэгслүүдээр тухай бүр нь сурталчилсан. 2022 оны 04 дүгээр сарын 01-30-ний хооронд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зэрэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын талаар Facebook group, цахим орчин, мэдээллийн хэрэгслүүдээр тухай бүр нь сурталчилсан. Сурталчилгаанд 150 гаруй иргэн хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуульд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зэрэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриатай Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй-2022 сарын аяныг зохион байгуулснаар багш, ажилчид, суралцагсдад аюулгүй байдал, эрүүл зэрэг соёлыг төлөвшүүлж, хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэлтэй болсон. | 100% |
| | 97 | Отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хүргэх, мал сүргээ онд оруулах талаар отор хүлээн авагч аймаг, | 2021 | Онцгой комисс | | | Архангай аймгийн Цэнхэр сумын Ширдгийн гол, Гүүт, Шийрт гэх газруудад 6 малчин өрхийн бод 282, 352 бог нийт 634 толгой мал өвөлжиж хаваржихаар байна. Тухайн аймаг, сумын захиргааны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сумдтай хамтран ажиллах замаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хадгална. | | | | | байгууллагат Хүн эмнэлэг, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлж, тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг гэрээ хийсэн.<br>4 дүгээр багийн нутаг дэвсгэрт Завхан аймгийн Алдархаан сумаас үхэр 102, хонь 110 толгой малтай өрх, Өвөрхангай аймгийн Төгрөг сумаас 400 хоньтой өрх тус тус өвөлжиж хаваржихаар байна. Тэдэнд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг үзүүлэх болно | |
| **5.2.“Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| | 98 | Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн хандив тусламжийг шаардлагатай газар, объектуудад хуваарилах ба сумын Засаг даргын нөөц сангийн гамшгаас хамгаалах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 2021-2022 | Онцгой комисс | | | Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулахад Засаг даргын нөөцөөс 2021 онд 46,027,220 төгрөг, 2022 онд 10,598,980 төгрөгийг тус тус зарцуулаад байна | 100 |
| | 99 | Цар тахлаас урьдчилан сэргийлэх, томуугийн вакцинд төрийн албан хаагчид, өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, пост штабт ажиллаж байгаа иргэдийг хамруулна. | 2021-2022 | ЭМТ | | | Ковидын вакцин 3.4 дүгээр тунд-519 хүн Томуугийн вакциныг:<br>Жирэмсэн- 46, архаг хууч өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан-237, эмнэлгийн ажилтан-38 иргэд хийсэн. Элэгний В вирусийн вакциныг-159 хүнд тус тус хийсэн. | 100 |
| | 100 | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулна | 2021-2022 | ЭМТ<br>ЕБС<br>СӨББ | | | Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг улирлын томуугийн вакцинд хамруулсан.<br>Томуугийн вакцинд:<br>ЕБС-ийн хүүхэд 39<br>СӨББ-ын хүүхэд-705<br>Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд хийх заалттай, үлдсэнийг нь ЕБС-ийн хүүхдүүдэд хийсэн. | 100 |
| | 101 | Халдварт өвчний голомтод ажилласан албан хаагчдад | 2021-2022 | ЭМТ | | | 2021 онд Халдварт өвчний голомтод ажилласан албан хаагчдад илүү цагийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | урамшуулал, дэмжлэг олгоно. | | | | | 52,0 сая төгрөг, 49 ,0 сая төгрөгийн тэтгэмж олгосон.<br>2022 онд Халдварт өвчний голомтод ажилласан албан хаагчдад илүү цагийн 76,0 сая төгрөг, 108,0 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон. | |
| | 102 | Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд хэрэглэгдэх вирусийн эсрэг эм, сонгомол антибиотик, үрэвслийн эсрэг эм, тариа, оношлуур, хамгаалах хэрэгслэлийн нөөцийг бүрдүүлнэ. | 2021-2022 | ЭМТ | | | Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл:<br>Бээлий 15200 хос, Малгай 3701, маск 7000, N95-2060, комбинезон 159, нэг удаагийн халад 1620, Нүүрний хаалт -1310, нүдний шил-162. Оношлуур -700 ш,<br>Антибиотик, вирусын эсрэг эм:<br>Эритромицин 2500 таб,<br>Амоциклион 200 мг-3700 таб,<br>Арбидол-3500<br>Эргоферон -270<br>Цефатоксим -664 фл,<br>Ремдисивир-260<br>Цефозолин-1205<br>Цитризит-4651<br>Витамин С-5500<br>Витамин Д-2000<br>Аскортин-35000<br>Спирт -17 л<br>Санитол 15 л<br>Хлорын шохой-41 кг<br>Нөөцийг бүрдүүлсэн. | 100 |
| | 103 | Тархвар судлал, халдварт, зоонозын халдварт өвчний чиглэлээр эмч мэргэжилтнийг бэлтгэх, сургаж, чадавхжуулах, орон тоог нэмэгдүүлнэ. | 2021-2022 | ЭМТөв | | | Тархвар судлал, халдварт, зоонозын халдварт өвчний чиглэлээр 3 их эмч суралцаж, 1 дотрын их эмч нарийн мэргэжлээр төгсөөд ажиллаж байгаа.<br>ЭМГ-аас шинэ эмнэлэг ашиглалтад орохоор орон тооны асуудал шийдэгдэнэ. | 100 |
| | 104 | Сумын Эрүүл мэндийн төвийн халдвартын тасгийг өргөжүүлж, байрны асуудлыг шийдвэрлэнэ. | 2021 | Онцгой комисс ЭМТөв | | | ЭМТ-ийн хуучин байрыг ковидын эмнэлгээр 58 орыг дэлгэн үйл ажиллагаагаа явуулсан. | 100 |
| | 105 | Цар тахлын үед ажиллах тусгаарлах болон | 2021 | Онцгой комисс | | | 2021 оны 06 дугаар сараас 08 дугаар сарыг дуусталх хугацаанд ЕБС-ийн 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусгаарлан ажиглах байрыг томилгоожуулж, бэлэн байдлыг хангана. | | | | | хүүхдийн дотуур байрыг тусгаарлан ажиглах байраар ашиглаж үйл ажиллагаа явуулж байсан.<br>Мөн Тусгаарлан ажиглах байрны нөөцөд 2 зочид буудлыг эрэмбэлж хариуцсан эздтэй гэрээ хийж бэлтгэсэн | |
| | 106 | Халдварт хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах орчин үеийн дэвшилтэт технологит суурилсан байгууламжийг бэлэн болгоно | 2021 | Онцгой комисс | | | Ковидоос гарсан хог хаягдлыг тусгай өнгийн (Шар) уутанд савлаж хог түр хадгалах байранд хадгалж халдваргүйжүүлэлт хийсний дараа төвлөрсөн хогийн цэгт асгаж устгал хийдэг | 100 |
| | 107 | Хорио цээрийн дэглэмийн үед хэмнэгдсэн зардлыг тооцож, нэн шаардлагатай арга хэмжээнд сумын Онцгой комиссын шийдвэрийг үндэслэж, зарцуулна. | 2021 | Онцгой комисс | | | Онцгой комиссоос ЭМТ-өөс тусгаарлах эмнэлэг болон ажиглах байранд ажиллаж байсан эмч, сувилагч нарын халаад, малгай, нүүргэвч, бээлий авахад 242,5 мянган төгрөг, түргэн тусламжийн 2 автомашины засварын зардалд 6,286,5 мянган төгрөг, тусгаарлан ажиглах байранд хэвтэн эмчлүүлэгч нарын мах, хоол, хүнсний зардалд 13,812,450 төгрөг, ахуй хэрэглээний зардалд 1,918,950 төгрөг, хүчилтөрөгчийн баллон /10 л-ийн/ - 2 ш 1,000,0 төгрөг, ЭМТ-ийн халаалтгүй өрөөг халаалттай болгох засварт 500,0 төгрөг, тусгаарлах эмнэлэгт угаалгын машин 350,0 төгрөг, 1 иргэн 1 шинжилгээний 800 сорьцын үнэ 10,000,0 төгрөг, нийт 34,110,400 төгрөгийг Засаг даргын нөөцөөс гарган шийдвэрлэсэн.<br>ЕБС, 1, 2 дугаар цэцэрлэг, ЗДТГ-т мананцар үүсгэгч тус бүр 1 ш-ийг, нийт 1,400,0 мянган, төгрөгөөр Засаг даргын нөөцөөс авч өгсөн | 100 |
| | 108 | Сурагчдад цахимаар явуулах хичээлийн цагийг зохистой хэмжээнд хүргэхийн зэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн хоцрогдол | 2021 | ЕБС | | | Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/292, А/525 дугаар “Түр журам батлах тухай” тушаалыг мөрдөж цар тахлын халдварын тархалтаас хамаарч танхимын болон танхимын бус хосолсон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гаргахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | хэлбэрээр хичээл сургалтыг зохион байгуулж байна. Зайн сургалтын хуваарь гарган 6-12 ангийн сурагчдад “google meet8” zoom аплейкшин ашиглан хичээлээ зааж байна.Мөн теле хичээлийн хуваарийг сурагчдад хүргэж дасгал даалгаврыг хянан эргэх холбоотой ажилласан. | |
| | 109 | Сургууль, цэцэрлэг бүр цахим, теле хичээл бэлтгэн, технологийн сан бүрдүүлж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж, танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин, тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна. | 2021 | ЕБС СӨББ | | | Багш бүр medlee.mn–д байршсан хичээлүүдийг татан авч теле хичээлийн сан бүрдүүлж ажиллаж байна.<br>БМДИ-ээс зохион байгуулсан “Хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх нь” сургалтад 3 багш оролцож ирээд багш нартаа сургалт зохион байгуулсан.<br>Цахим хичээлд шилжих хугацаанд дунд ахлах ангийн багш нар цахим хичээл бэлтгэн зааж байна. | 100 |

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлж дүгнэлээ.

Үнэлгээ /тоон үзүүлэлтээр/

Үнэлгээний дүн

| Д/д | Арга хэмжээ | Хувь | оноо |
|---|---|---|---|
| 1.1 | 6 | 95 | |
| 1.2 | 17 | 86.4 | |
| 1.3 | 8 | 92.5 | |
| 1.4 | 7 | 85.7 | |
| 1.5 | 4 | 91 | |
| 2.1 | 10 | 90 | |
| 2.2 | 6 | 86.1 | |
| 2.3 | 14 | 97 | |
| 3.1 | 10 | 100 | |
| 3.2 | 4 | 100 | |
| 4.1 | 5 | 98 | |

| | | | |
|---|---|---|---|
| 5.1 | 6 | 100 | |
| 5.2 | 12 | 100 | |
| | 109 | 93.7 % | |